



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/237

Мандалговь

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалтын ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2021 оны А/139 дугаар тушаалын дагуу 2021 оны 6 дугаар сарын 24-ний өдрөөс 7 дугаар сарын 01 хүртэлх хугацаанд Цагаандэлгэр сумын үхэр болон бог малыг гоц халдварт шүлхий өвчний дархлаажуулалтад бүрэн хамруулах, малчид, мал бүхий иргэдэд тов хүргэж, зарлан мэдээлэлж ажиллахыг Цагаандэлгэр сумын Засаг дарга нар (Д.Буджав) үүрэг болгосугай.

2. Шүлхийн дархлаажуулалтад хамруулах малын тоо, вакцины хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Дархлаажуулалтын ажлыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж шуурхай үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Ш.Мөнхдүүрэн), захирамжийн хэрэгжилтийг хангуулж, тайлагнаж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очирт)-т тус тус даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210236

Аймгийн Засаг даргын 2021 оны
᠙᠘ дугаар сарын ᠑᠘-ны өдрийн
᠕/᠑᠘7 дугаар захирамжийн хавсралт



ШҮЛХИЙ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ВАКЦИНД ХАМРАГДАХ МАЛЫН ТОО, ВАКЦИНЫ ХУВААРЬ

№	Сумын нэр	Малчин өрх	Шүлхийн дархлаажуулалтанд хамрагдах малын тоо				Тун
			Үхэр	Хонь	Ямаа	Бүгд	
1	Цагаандэлгэр	274	3,369	89,347	63,180	155,896	79,700